



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

“Компанийн 2018 оны санхүүгийн
тайлан батлах, хуримтлагдсан ашгаас дүрмийн сан,
нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 62 дугаар зүйлийн 62.1.9, 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” хаалттай хувьцаат компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хавсралт ёсоор баталсугай.

2. “Үндэсний давхар даатгал” хаалттай хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг улируулан томилсугай.

3. “Үндэсний давхар даатгал ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангийн хуримтлагдсан ашгаас 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөгөөр компанийн дүрмийн санг, 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөгөөр нөөц сангийн хөрөнгийг тус тус нэмэгдүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Наранцогт/-д даалгасугай.

4. Энэ тушаалын нэгдүгээр заалтаар батлагдсан санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажиллахыг компанийн гүйцэтгэх захирал /Г.Энхтайван/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Наранцогт/-д тус тус даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР